



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.05.01 № 1369
танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН М.ЭНХМАНЛАЙ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Мянганбуугийн Энхманлайгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Мянганбуугийн Энхманлайгийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Мянганбуугийн Энхманлайгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (.1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: .1. хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
М.ЭНХМАНЛАЙГИЙН
“УЛААНБААТАР ИННОВАЦИ - 2020” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Инноваци бол хөгжлийн шийдэл гэсэн үзэл баримтлалаар нийслэл Улаанбаатар хотоо хурдтай, тулхтай хөгжлүүлэх хөтөлбөрийг санал болгож байна.

1. Улаанбаатар хотод инновацийн төвийг төр, хувийн хэвшил, олон улсын байгууллагын оролцоотойгоор 3-аас доошгүйг байгуулна.
2. Нийслэлд тулгамдсан асуудал бүрийг шийдвэрлэх ажлыг инновацийн төвд судлаж, гарц, шийдлийг боловсруулан бизнесийн зарчмаар шийдвэрлэх боломжийг бий болгоно.
 - a. Утааг бууруулах бус утаа ялгаруулах эх үүсвэрт инновацийн шийдэл нэвтрүүлэх замаар утааг арилгах ажлыг эхлүүлнэ.
 - b. Хөрсний бохирдлыг бууруулахын тулд нүхэн жорлонг халах, жилийн 4 улиралд нийцэх эко жорлон бий болгох төслийг инновацийн төвд судлан бүтээнэ.
 - c. Замын түгжрэлийг бууруулах арга замыг инновацийн төвд шийдвэрлэн, зохистой шийдлийг бизнесийн арга замаар шийдвэрлэнэ.
 - d. Авто зогсоолд инноваци нэвтрүүлж, нэг талаас нийслэлийн орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талаас түгжрэлийг бууруулах боломжийг бий болгох ажлыг эхлүүлнэ.
 - e. Хог хаягдлыг менежментэд инноваци нэвтрүүлнэ.
 - f. Хаягдал түүхий эдийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг бий болгоно.
 - g. Үер усны асуудалд анхаарч, инновацийн төвд судлан, айл өрхөд аюулгүй, ээлтэй байх технологийг нэвтрүүлж, үерийн усыг ногоон байгууламжид эргэж ашиглах төсөл хэрэгжүүлнэ.
 - h. Хотын ногоон байгууламжийг богино хугацаанд нэмэгдүүлэх, айл бүрийн хашааг ногоон орчин болгох хялбар шийдлийг бий болгоно.
 - i. Нийслэлийн төр захиргааны байгууллагын бүхий л мэдээлэл харилцаанд инноваци нэвтрүүлэх замаар иргэдтэй харилцах, иргэдэд мэдээлэх тогтолцоог сайжруулна.
 - j. Авто зам, явган замын технологид инновац нэвтрүүлнэ.
3. Инновацийн төвөөр дамжуулан экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг бий болгож, гадаадын хөрөнгө оруулалтыг татах тогтолцоог нэвтрүүлнэ.
4. Инноваци болон бүтээлч эдийн засгийг хослуулах замаар үндэсний үйлдвэрлийг хөгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, үндэсний брэндийг бий болгох цогц ажлыг эхлүүлнэ.
5. Инновацийн сан байгуулж, санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.
6. Инновацийн төслүүдийг санхүүжүүлэх хялбар, ухаалаг боломжийг банк санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
7. Нийслэлийн Инновацийн шагнал бий болгож, инновацийн шилдэг шийдлийг шалгаруулдаг тогтолцоо бий болгоно.
8. Нийслэлд инновацийн тэтгэлэг олгох журам боловсруулж, нийгмийн шинжтэй инновацийн төсөлд тэтгэлэг олгох тогтолцоог бий болгоно.
9. Инновацийн төвийг Их дээд сургуулиудтай хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
10. Жил бүр “Улаанбаатар Инновацийн 7 хоног” зарлаж инновацийн бүтээгдэхүүнүүдийг сурталчлах, хөрөнгө оруулалт татах нөхцлийг бүрдүүлнэ.

